

**АГААР ЦЭВЭРШҮҮЛЭГЧ
+
ИОНЖУУЛАГЧ +
ЧИЙГШҮҮЛЭГЧ
АЕ-200**

Ашиглалтын заавар



АГУУЛГА

1. Техникийн үзүүлэлтүүд	3
2. Цэвэршүүлэгчийн онцлог	3
3. Бүтээгдэхүүний зураг	6
4. Ажиллуулах заавар	7
5. Ажиллагааны тодорхойлолтууд	9
6. Чийгшүүлэгчийн ажиллагаа	11
7. Шүүлтүүрийг цэвэрлэх зөв дадал	12
8. Анхаарах зүйлс	13
9. Ухаалаг үнэр мэдрэгчийн систем	14
10. Эвдрэлийг тодорхойлох	15

1.ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүтээгдэхүүний нэр	Агаар цэвэршүүлэгч		
Цэвэршүүлэх арга	1. Хүйтэн каталист шүүлтүүр 2. Эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр 3. Нян бактерийн эсрэг шүүлтүүр 4. Өндөр үр дүнтэй ХЕПА шүүлтүүр, 5. Сөрөг цэнэгтэй ионжуулагч ялгаруулагч 6. Хэт ягаан туяат ариутгалын гэрэл, 7. Чийгшүүлэгч: их, дунд, бага		
Цэвэрлэх талбай	40 м2		
Цэвэр жин	6,8кг		
Агаар цэвэршүүлэх чадал	220м³/цаг (PM 2.5-д)		
Сэнсний хурд	Өндөр хурд: 5,8м-6,8м/сек	Дунд хурд: 3,5м-4,5м/сек	Бага хурд: 1,5м-2,5м/сек
Дуу чимээ	Өндөр 55dB	Дунд 30dB	Бага 22dB
Сэнсний хурдны давтамж	3 хурд: Өндөр, дунд, бага		
Хүчдэлийн хэмжээ	АС 220В-240В		
Давтамжийн хэмжээ	50/60Гц		
Хэмжээс	Урт360хӨргөн195хӨндөр565мм		
Цахилгаан	66w		
Нэмэлт	Чийгшүүлэгч, ухаалаг үнэр мэдрэгч, Чийгшил хэмжигч		

2. ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГ

Хүйтэн каталист шүүлтүүр

1. Хүйтэн каталист нь хэт ягаан туяаны гэрэл, нарны гэрэл, өндөр температур, даралт зэрэг гадны нөлөөгүй энгийн амьдрах орчны каталист нөлөөг үзүүлнэ.

2. Энэ нь хүчилтөрөгчтэй урвалд орох формальдегид, аммони, бензин, TVOC, водород сульфид болон бусад хорт хийг задлан, ус ба карбон диоксидод хувиргадаг.
3. Хүйтэн каталист нь задлах процессын үеэр өөрөө урвалд ордоггүй учраас 5 хүртэл жил ашиглагдах боломжтой байдаг.
4. Каталистын үндсэн орц нь хүнс, анагаахын бодис байдаг. Тиймээс бүтээгдэхүүн нь хоргүй, зэвэрдэггүй, галд үл шатамхай. Энэ нь энгийн нөхцөлд ажиллаж, зөвхөн ус ба карбон диоксид үүсгэдэг.
5. Хүйтэн каталист нь мод, тавилга, ханын цаас, хивс, орны бүтээлгээс ялгарах формальдегид, аммони, бензин, TVOC, водород сульфид болон бусад хорт бодисыг цэвэрлэхэд хэрэглэгдэнэ.

Эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр

- Эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр нь өндөр үр дүнтэй бодисуудыг агуулдаг. Энэ нь шингээлт, тоос цуглуулалтын өндөр чадвартай.

Нян бактерийн эсрэг шүүлтүүр

- Нян бактерийн эсрэг бодистой 5 микроны шүүлтүүр нь агаар дахь нян бактерийг үр дүнтэйгээр устгана.

Өндөр үр дүнтэй ХЕПА шүүлтүүр

- ХЕПА шүүлтүүрийн нягтрал нь 0,01 микрон бөгөөд 0,01 микрон болон түүнээс том хэсгүүдийг 99% ба түүнээс дээш хувиар шүүх чадвартай. Тоос, тоосонцор, хөгц, нян бактер, аллерги үүсгэгч болон бусад жижиг өчүүхэн хэсгүүд ХЕПА шүүлтүүрийг давж чадахгүй.

Сөрөг цэнэгтэй ион ялгаруулагч

- Ионжуулагч нь их хэмжээний анион буюу сөрөг цэнэгтэй ион ялгаруулж сөрөг цэнэгтэй хүчилтөрөгчийг үүсгэснээр агаар дахь тоос, тоосонцор, нян бактер, утаа зэрэг эерэг цэнэгт жижиг биетүүдийг өөрт татаж цуглуулдаг. Нийлж нягтарсан биетүүд доош унана. Биетүүдийн хэмжээ жижиг байх тусам баригдах нь илүү болдог.

Хэт ягаан туяат ариутгалын гэрэл

- 365 нм хэт ягаан туяаны гэрэл нь төрөл бүрийн нян бактерийг устгаж ариутгана. Хэт ягаан туяаны бактери устгагч гэрэл нь агаарыг цэвэршүүлж, утаа, хөгцнөөс үүсэх үнэрийг арилгана. Түүнчлэн, өрөөн дэх агаарыг цэвэршүүлэхийн сацуу вирус тархахаас сэргийлэх тодорхой хэмжээний сөрөг ион үүсгэдэг.


Чийгшүүлэгч

- Энэ төхөөрөмж нь чийгшүүлэгч ажиллагаатай. Хуурай цаг уурт хэрэглэгч доорхи нөхцөлд чийгшүүлэх функцийг ажиллуулж болно.
 - Агаарын чийгшлийг нэмэгдүүлэх, агаарын чанарыг сайжруулах. Утаа болон хөгцний үнэрийг дарах.
 - Арьсыг чийгшүүлэх
 - Хүний бодисын солилцоог сайжруулах, даралт ядралтыг багасгах

Ухаалаг үнэр мэдрэгч систем

- Энэ төхөөрөмж нь ухаалаг үнэр мэдрэгч системтэй. Төхөөрөмж нь агаарын чанарыг хянах дэлгэц (улаан /муу/, шар /энгийн/, ногоон /сайн/)-ийн дагуу сэнсний хурдыг автоматаар тохируулна.


3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗУРАГ





1	Хянах самбар	7	Бариул	13	Дэлгэцийн хавтгай
2	Чанарын үзүүлэлтийн самбар	8	Агаар гадагшлалт	14	Удирдлагын хүлээн авагч
3	Нүүрэн тал	9	Ар тал		
4	Дунд хайрцаг	10	Усны сав		
5	Чийгшилтийн мэдрэгч	11	Outfalls		
6	Үнэр мэдрэгч	12	Хяналтын товч		

4. АЖИЛЛУУЛАХ ЗААВАР

Шүүлтүүрийг авах бүдүүвч



1. Нүүрэн талыг онгойлгохдоо эрхий хуруугаа нүүрэн тал дээр байрлуулангаа төхөөрөмжийн бариулд холбогдсон нүүрэн хэсэг дээрх нүх рүү баруун гараа байрлуулж зөөлнөөр хөдөлгөнө.



3. 1 ба 2-р шүүлтүүрийг тээвэрлэлтийн хайрцаг савнаас гарга.

2. Гогцоог сумны дагуу эргүүлж 1 ба 2-р шүүлтүүрийг ээлжээр ав.


Шүүлтүүрийг суурилуулах бүдүүвч



1. Бүтээгдэхүүний дотор талд Шүүлтүүр 2 (Нян бактерийн эсрэг шүүлтүүр ба ХЕПА шүүлтүүр)-г буцааж хий. Анхаар: Тэмдэгтэй тал нь өөр лүү чинь харсан эсэхийг нягтлах.



2. Бүтээгдэхүүний дотор талд Шүүлтүүр 1 (Хүйтэн каталист ба эсийн идэвхжүүлэлттэй нүүрсэн шүүлтүүр)-г буцааж хий. Анхаар: Тэмдэгтэй тал нь өөр лүү чинь харсан эсэхийг нягтлах.



3. Шүүлтүүрүүдийг зөв байрлуулсан эсэхийг нягтлах. Шүүлтүүрүүдийг суурилуулахдаа гогцоонуудыг эргүүл.



4. Нүүрэн талыг суурилуулахдаа доод хэсгийг нь ховил руу хийгээд таглана. Нүүрэн тал нь өөртөө байрласан соронзонгоор тогтоно.

5. АЖИЛЛАГААНЫ ТОДОРХОЙЛОЛТУУД



1. Энэ бүтээгдэхүүн нь жижиг дугуй батерейгаар ажилладаг алсын удирдлагаар тоноглогдсон. Хэрэв алсын удирдлагыг удаан хугацааны турш ашиглахгүй бол батерейг салгана уу. Анхаар: Удирдлаганы товчнууд нь их биен дээрх ижил товчнуудтай ижил ажиллагаа, үүрэгтэйгээр ажиллана.



2. Төхөөрөмж ажиллаж эхлэн, жингэнэж дуугарна. Дижитал дэлгэцэнд төхөөрөмж ажиллаж эхэлснийг илтгэн ON гэсэн бичиг гарна.



3. ON/OFF товчийг дарахад дижитал дэлгэцэнд модны дүрс анивчина.



4. Timer товчин дээр дарахад төхөөрөмж ажиллах бөгөөд мөн ухаалаг үнэр мэдрэгч ч ажиллаж эхлэнэ. Төхөөрөмж агаарын чанараас шалтгаалан хурдаа өөрөө автоматаар тохируулна. Цаг 1-12 цагийн хооронд эхлэнэ. Тухайн хугацаа өнгөрөхөд төхөөрөмж өөрөө унтрана.



5. Speed control товч бага, дунд, өндөр гэсэн хэмнэлд шилжинэ. Дижитал дэлгэцэн дээр хурд харагдана.



6. Sleep товчин дээр дарахад төхөөрөмж хамгийн бага хурдаар ажиллах бөгөөд ухаалаг үнэр мэдрэгч унтрана. Speed болон


Sleep товнууд нь харилцан давхцахгүй байдлаар ажилладаг. Нэг нь асаалттай үед нөгөөх нь унтрана.



7. Anion товчийг дарахад сөрөг ионжуулагч ажиллана. Үүнийг асаасан үед Anion бичиг дүрс дэлгэцэн дээр харагдана. Ухаалаг үнэр мэдрэгч мөн ажиллаж эхэлнэ.



8. Sterilize товчийг хэт ягаан туяаны бактер устгагч гэрлийг ажиллуулах үед дарах ба Sterilize бичиг дүрс дэлгэцэн дээр харагдана. Үүнийг асаасан үед ухаалаг үнэр мэдрэгч мөн ажиллаж эхэлнэ.



9. Mist товчийг дарахад чийгшүүлэгч ажиллаж эхэлнэ.



10. Auto товчийг дарснаар энэ командын дагуу сөрөг ионжуулагч, ариутгагч, сэнсний хурд, чийгшүүлэгч ажиллаж эхэлнэ. Сэнсний хурд нь агаарын чанараас шалтгаалж автоматаар тогтоогдоно. Чийгшүүлэлт нь тухайн үеийн агаарын чанараас шалтгаалж автоматаар тохируулагдана.

6.ЧИЙГШҮҮЛЭГЧИЙН АЖИЛЛАГАА



1. Усны савыг дарж, 45° болгон татаж гаргана.



2. Тагийг цагийн зүүний эсрэг эргүүлнэ. Савны тагийг аваад усаар дүүргэнэ. Бэлэн болсон үед таглаад цагийн зүүний дагуу эргүүлж түгжинэ. (Резинэн жийргэвчийг байгаа эсэхийг шалгаарай.)



3. Усны савыг 45° налуугаар байрлуулан буцааж хийнэ.



4. Усны савыг буцаан байрлуулсны дараа чийгшүүлэх товчийг дарахаасаа өмнө хөөс байгаа эсэхийг шалгана уу.

Чийгшүүлэлтийн хэмжээг их, дунд, бага хэмжээгээр Mist товчийг дарж тохируулна.



5. Чийгшүүлэгчийг ашиглаагүй үедээ усны савыг суллаж хуурай байлгаарай.

7. ШҮҮЛТҮҮР, ЧИЙГШҮҮЛЭГЧ, ИОНЖУУЛАГЧ ИЙГ ЦЭВЭРЛЭХ ЗӨВ ДАДАЛ




Шүүлтүүрийн арчилгаа ба цэвэрлэгээ

Шүүлтүүрийн ашиглах хугацааг уртасгахын тулд хортой хий, үнэрийг арилгаж бактерийг устгахаар үе үе нарны шууд тусгалд тавьж байх ёстой.



Чийгшүүлэгчийн арчилгаа ба цэвэрлэгээ

Нимбэгийн хүчилтэй цэвэрлэгч бодисыг зааврынх нь дагуу найруулаад чийгшүүлэгчдээ хийн 10-20 минут байлгана. Шүдний сойз буюу алчуураар цэвэрлэн усыг асгана. Цэвэр усаар дахин нэг удаа зайлна.



Ионжуулагчийн арчилгаа ба цэвэрлэгээ

Бийрийг цэвэрлэгээний багаж болгон ашиглаж, үзүүрээр нь ионжуулагчийн дээд хэсэг дэх ионжсон агаарын урсгал гарах хэсэгт хэсэг болгоны тоосыг цэвэрлэнэ үү.

8. АНХААРАХ ЗҮЙЛС

Төхөөрөмжийг дараах орчинд ашиглахыг хориглоно.

1. Ашиглаж байх үед агаарын урсгалыг чөлөөтэй байлгах үүднээс хамгийн багадаа хоёр тал болон хойд талд нь 50 см, дээд талд нь 80 см хоосон зайтай байлгана. Төхөөрөмж унаж хэмхрэхээс болгоомжлон эд зүйлсийг дээр нь тавьж болохгүй. Мөн унагааж эвдрэхээс сэргийлж тэгш бус гадарга дээр бүү тавина уу.
2. Төхөөрөмжийн үйл ажиллагаанд нөлөөлөх тул түүнийг хөшиг болон тавилгын дэргэд тавьж болохгүй.
3. Энэхүү төхөөрөмжийг чийглэг болон өндөр температуртай газар хэрэглэж болохгүй.
4. Төхөөрөмжийг шингэн хий ашигладаг төхөөрөмж, халаагч төхөөрөмж, зуухны ойролцоо ашиглаж болохгүй.
5. Энэ төхөөрөмжийг 5-40° температурт ашиглахад тохиромжтой бөгөөд зөвхөн дотор ашиглагдахаар бүтээгдсэн болно.

Анхааруулга

1. Төхөөрөмжийг хөдөлгөхдөө тогноос салгана уу.
2. Аюулгүйн үүднээс хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хараа хяналтгүйгээр төхөөрөмжийг ажиллуулахыг бүү зөвшөөр. Алсын удирдлага эвдрэхээс хамгаалж хүүхдээр тоглуулж болохгүй.
3. Төхөөрөмжийг ажиллуулж эхлэхээс өмнө залгуур болон цахилгааны үүрийг шалга. Цахилгааны утас, хоолойг нугалж болон татаж болохгүй. Контактгүй болох, тогонд цохиулахаас сэргийлэн эдгээрийг дураараа сольж болохгүй.
4. Тогийг салгахдаа нойтон гараар хүрч болохгүй. Төхөөрөмжийн ард байрлах шошгон дээр заасан хүчдэлтэй цахилгааны залгуурын хүчин чадал тохирч байгаа эсэхийг шалгана уу.
5. Хэрэв төхөөрөмж эвдэрвэл аюултай учир өөрсдөө задалж засаж болохгүй. Төхөөрөмжийг ашиглахаа зогсоож албан ёсны төлөөлөгчтэй засуулахаар холбогдоно уу.
6. Энэхүү төхөөрөмжийг эвдрэл, ослоос сэргийлэх үүднээс өөр шилжүүлсэн программтай удирдлага, цаг тохируулагч, автомат хэрэгсэлтэй ашиглахыг хориглоно.
7. Осол гаргахгүйн үүднээс төхөөрөмжийн завсар зай болон их биений залгаастай хэсгүүдэд (агаар орох, гарах хэсэг гэх мэт) гараа хүргэх болон жижиг зүйлс хийхийг хатуу хориглоно.
8. Агаар орох, гарах хэсгийг таглахыг хориглоно, жишээлбэл орох гарах хэсэгт ямар нэгэн зүйл тавьж болохгүй.
9. Энэ бүтээгдэхүүн нь өдөр тутмын сэнс, тоос цэвэрлэгч, хиншүү сорогчын үүргээр ашиглагдах ёсгүй.

10. Хэрэв усны савнаас ус гоожвол, тогийг салгаж бүтээгдэхүүнийг босоо байдалд 30 минут байлгасны дараа ашиглаж эхэлнэ үү.
11. Үнэр мэдрэгчийн болон чийгшил мэдрэгчийн орчинг доголдохоос сэргийлж үргэлж цэвэр байлгана уу.
12. Төхөөрөмжийг шингэн хий ашигладаг төхөөрөмж, халаагч төхөөрөмж, зуухны ойролцоо ашиглаж болохгүй
13. Хэрэглэсний дараа болон цэвэрлэхийн өмнө тогноос салгана уу.
14. Төхөөрөмжийн дотор конденсацис үүсэх усны дусал унахаас сэргийлж температурын хэлбэлзэл ихтэй том орчинд ашиглаж болохгүй.

9. Ухаалаг үнэр мэдрэгчийн системийн санах ойг суулгах заавар

Санах ой суулгахдаа:

Хэрэв агаарын чанарын үзүүлэлт улаан өнгөтэй ба төхөөрөмжийн тогийг гэнэт салгасан үед танд ухаалаг санах ойг шинээр суулгах шаардлага гарч болно. Үгүй бол дэлгэц улаан өнгөтэй хэвээрээ байна. Агаарын чанарын үзүүлэлтийн гэрэл анивчиж эхлээд үйл ажиллагааны горимд хүрэх хүртэл SLEEP товчийг усны дусал мэт чимээ гартал удаанаар дарна.

Анхаарах:

1. Төхөөрөмжид санах ой суулгах алхмуудыг хийж ажиллуулахдаа агаарын бохирдолгүй, цэвэр орчинд хийнэ гэдгийг анхаарна уу.
2. Хэрэв төхөөрөмжид санах ой суулгах алхмуудыг агаарын бохирдолтой орчинд хийвэл дэлгэцийн гэрэл буруу ажиллах магадлалтай.

10. ГЭМТЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Асуудал	Шийдэл
Агаар гарах хэсгээс агаар гарахгүй байх	Төхөөрөмжийг асаасан эсэх, цахилгаанд залгагдсан эсэхийг шалгах
Гарч буй агаарын хэмжээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц буурсан	Шүүлтүүр бохирдсон тул цэвэрлэх буюу солих. Тоос болон бусад биетийг салгахын тулд шүүлтүүрийг бага зэрэг сэгсэрч болно.
	Шүүлтүүр хайрцагтайгаа байна. Баглаа боодлыг нь салгаж авах.
Төхөөрөмжийг удаан хугацаагаар ажиллуулсан ч агаарын чанар мэдэгдэхүйц сайжрахгүй байх	Шүүлтүүрийн давхаргыг суурилуулах дарааллыг шалгах
	Шүүлтүүр ашиглалтгүй болсон тул түүнийг шинээр солих
Шүүлтүүрүүдийг хэзээ шинээр солих ёстой вэ?	Эхний шүүлтүүр: Гадаргуу нь бохир, өнгөтэй гандсан. Хүйтэн каталистын жижиг нүхнүүд бөглөрсөн болон карбоны өнгө мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Ашиглах хугацаа: 8-14 сар.
	Хоёрдох шүүлтүүр: Цагаан ХЕПА шар, хар, хөгцтэй болсон. Ашиглах хугацаа: 8-14 сар.
	Сануулга: Шүүлтүүрийн ашиглах хугацаа нь агаарын чанар болон ашигласан хугацаанаас хамаарна
Унтарсан	Автомат аюулгүйн унтралтыг унтраасан эсэхийг шалгах

ЭКО АГААР, ЭРҮҮЛ АМЬДРАЛ